



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/368

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 03/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шинжилгээний албанд хими биологийн шинжилгээ хийхэд шаардлагатай лабораторийн техник багаж хэрэгсэл худалдан авах зардалд 16,852,000 (арван зургаан сая найман зуун тавин хоёр мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 03/07 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100769